



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/309

Эрдэнэт

Тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 06 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдах шагайн харвааны 27 дахь удаагийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгийг төлөөлж оролцох баг тамирчдад 1500000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 1500000 /Нэг сая таван зуун мянган / төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын "Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
6 дугаар сарын 24 ны өдрийн
1309 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хоног	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Унааны зардал	Төгрөг	9 хүн	2	15000₮	270000₮
2.	Хоол	Төгрөг	9 хүн	4	8000₮	288000₮
3.	Байр	Төгрөг	9 хүн	3	15000₮	405000₮
4.	Оролцоо	Төгрөг				540000₮
	Дүн	Төгрөг				1503000₮

00